

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2006 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

“Аудиторт даатгалын байгууллагад аудит
хийх эрх олгох тухай журам” батлах тухай

Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Аудиторт даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.
3. Энэхүү журмыг 2006 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

АУДИТОРТ ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу Сангийн яамнаас тусгай зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсэн аудитын байгууллагын аудиторт Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 33.2.2 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2-т заасны дагуу даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, энэ журамд заасан шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавихад энэ журмын зорилго оршино.

Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх) аудитын байгууллагын аудиторт эрх олгосон, сунгасан, хүчингүй болгосон тухай бүр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

Даатгалын байгууллага гэдэгт даатгалын компани, даатгалын зуучлагч, хохирол үнэлгээний компаниудыг ойлгоно.

ХОЁР. АУДИТОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1 Даатгалын байгууллагад аудит хийх эрх хүссэн аудиторт дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- 2.1.1 Сангийн яамнаас тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлж, аудитын үйл ажиллагааг 5-аас доошгүй жил эрхэлсэн аудитын байгууллагад аудитороор ажилладаг байх;
- 2.1.2 Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
- 2.1.3 Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлээр хориглосон заалтыг зөрчөөгүй байх;
- 2.1.4 аудитын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх;
- 2.1.5 Хорооноос зохион байгуулах эрх олгох сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх;
- 2.1.6 даатгалын талаарх холбогдох хууль тогтоомж, журам дүрмүүдийн талаар зохих мэдлэгтэй байх;
- 2.1.7 мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй байх.

ГУРАВ. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ ЭРХ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ.

3.1 Энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан аудитор нь даатгалын байгууллагад аудит хийх хүсэлтээ Хороонд гаргаж, дор дурдсан баримт бичгийн хамт ирүүлнэ. Үүнд:

- 3.1.1 эрх олгохыг хүссэн аудиторын өргөдөл;
- 3.1.2 эрх хүссэн аудиторын ажиллаж буй аудитын байгууллагын тухайн аудиторт даатгалын байгууллагад аудит хийх эрх олгохыг хүссэн албан бичиг, аудиторын ажил байдлын тодорхойлолт;
- 3.1.3 аудиторын тодорхойлолтыг энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу гаргаж ирүүлнэ. (Сангийн яам, Мэргэшсэн нягтлан бодогчийн институтээс олгосон мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар болон иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргасан байна);
- 3.1.4 аудитын байгууллагын удирдлагын тодорхойлолтыг энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу гаргаж ирүүлнэ;
- 3.1.5 тухайн аудиторын ажиллаж буй аудитын байгууллагын дүрэм, аудитын үйлчилгээний дотоод стандарт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 3.1.6 тухайн аудиторын ажиллаж буй аудитын байгууллагын сүүлийн 5 жилийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг нотлох баримтын хамт;
- 3.1.7 Хорооноос зохион байгуулах эрх олгох сургалтанд оролцож, авсан гэрчилгээ;
- 3.1.8 Хорооны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох тухай журам”-ын 2 дугаар хавсралтын 2.4-т заасан зохицуулалтын үйлчилгээний төлбөрийг төлсөн баримт.

ДӨРӨВ. АУДИТОРТ ЭРХ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ.

- 4.1 Хороо аудиторт даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох сургалтыг нийтэд зарлан мэдээлсний үндсэн дээр зохион байгуулах бөгөөд холбогдох шалгалтад тэнцсэн аудиторуудад гэрчилгээ олгоно.
- 4.2 Хороо аудитороос ирүүлсэн бүрдэл хангасан хүсэлт болон бусад шаардлага хангасан бичиг баримтуудыг хүлээн авснаас хойш ажлын 45 хоногийн дотор хянан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, эрх олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.3 Хорооны ажлын алба нь аудит хийх эрхээ сунгуулах талаар аудитороос гаргасан хүсэлт болон аудитын байгууллагын тухайн даатгалын салбарт явуулж буй үйл ажиллагааны үр дүнг үндэслэн эрх сунгах, эсэх асуудлыг Хорооны хуралд танилцуулж, холбогдох шийдвэрийг 3 жил тутам гаргуулна.
- 4.4 Хороо нь дараах үндэслэлээр аудиторын даатгалын байгууллагад аудит хийх эрхийг түдгэлзүүлж болно. Үүнд:
 - 4.4.1 холбогдох хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн;
 - 4.4.2 санхүүгийн тайланг санаатай буюу санамсаргүйгээр буруу баталгаажуулсан, аудитын үйл ажиллагааны зарчмыг зөрчиж, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэсэн;
 - 4.4.3 Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй;
 - 4.4.4 энэ журамд заасан шаардлагыг зөрчсөн буюу шаардлага хангахгүй болсон;
 - 4.4.5 Хорооноос ногдуулсан торгуулийг хугацаанд нь төлөөгүй;
 - 4.4.6 эрх олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

- 4.4.7 Хорооны 33 дугаар тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох тухай журам”-ийн 2 дугаар хавсралтын 2.4-т заасны дагуу жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй;
- 4.4.8 хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 4.5 Аудиторын даатгалын байгууллагад аудит хийх эрхийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:
- 4.5.1 Хорооноос тогтоосон хугацаагаар (энэ хугацаа 6 сараас хэтрэхгүй байна);
- 4.5.2 Хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.
- 4.6 Хороо нь дараах үндэслэлээр даатгалын байгууллагад аудит хийх аудиторын эрхийг хүчингүй болгоно. Үүнд:
- 4.6.1 даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан аудитор хүсэлт гаргасан;
- 4.6.2 даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан аудиторын ажиллаж байгаа аудитын байгууллага татан буугдсан;
- 4.6.3 Аудитын байгууллага нь Хороотой хамтран ажиллахаас татгалзсан;
- 4.6.4 аудитор нь даатгалын байгууллагад аудит хийх эрхийг авахдаа хуурам бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 4.6.5 холбогдох хууль, журам болон энэ журамд заасан шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;
- 4.6.6 даатгалын байгууллагад аудит хийх аудиторын эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- 4.6.7 даатгалын байгууллагын нууцлалтай холбогдсон мэдээллийг бусдад задруулсан, дамжуулсан нь нотлогдсон;
- 4.6.8 хуурамч дүгнэлт гаргасан;
- 4.6.9 Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй;
- 4.6.10 эрх авсан аудиторын ажиллаж буй аудитын байгууллагын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн дагуу авсан аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон.
- 4.7 Хороо эрх олгохоос татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргасан аудиторт албан ёсоор хүргүүлнэ.

ТАВ. ДААТГАЛЫН АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1 Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан аудиторын ажиллаж буй аудитын байгууллага нь даатгалын байгууллагатай Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн гэрээ байгуулах ба Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан аудитын үйл ажиллагаанаас гадна дор дурдсан үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:
- 5.1.1 даатгалын байгууллагын санхүүгийн тайлан (даатгалтай холбоотой санхүүгийн нэмэлт тайлан мэдээ, мэдээлэл, орлого зарлагын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга), данс бүртгэл, бусад шаардлагатай санхүүгийн баримт, материалыг шалган баталгаажуулах;

- 5.1.2 аудитын үйл ажиллагаанд аудитын олон улсын болон үндэсний стандарт, мөн даатгалын салбарын олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг мөрдөх;
 - 5.1.3 санхүүгийн баримтад тулгуурлан магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
 - 5.1.4 санхүүгийн байдлын талаар даатгалын байгууллагад зөвлөх;
 - 5.1.5 Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар, журмын хүрээнд нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу хөтлөх, нэвтрүүлэхэд нь туслах, зөвлөх;
 - 5.1.6 даатгалын байгууллагын менежментийн асуудлаар зөвлөгөө өгөх, дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд нь туслах;
 - 5.1.7 давхар даатгалын үйл ажиллагаа нь Хорооноос баталсан “Давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын дагуу явж буй эсэх болон даатгагчийн давхар даатгалын бодлого, гэрээ, тайлан, давхар даатгалын нөхөн олговрын төлөгдсөн байдал, хураамж, давхар даатгагч компанийн санхүүгийн болон төлбөрийн байдлын талаар үнэлэлт, дүгнэлт гаргах;
 - 5.1.8 мөнгө угаах, алан хядах ажиллагааны эсрэг хууль тогтоомжийг биелүүлж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 5.1.9 даатгалын нөхөн олговор олголтын болон баримт бүрдүүлэлтийн байдалд үнэлгээ өгөх;
 - 5.1.10 даатгагчийн төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхид үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 5.1.11 даатгагчийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, компанийн хувьцаа, ногдол ашиг хуваарилалт, зээл олголтын байдлыг хянаж, үнэлэлт дүгнэлт гаргах;
 - 5.1.12 даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, хуваарилалт нь зохих журмын дагуу байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 5.1.13 даатгагчийн гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагын хэмжээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хоорондын харьцааг хянаж, дүгнэлт гаргах.
- 5.2 Аудитор нь шалгаж судалсан санхүүгийн тайлан болон баримтад хувийн тэмдэг дарах бөгөөд гаргасан дүгнэлтээ зөвлөмж болон санхүүгийн тайланд хийсэн тохируулгын болон залруулгын бичилтийн хамт аудитын байгууллагын даргын гарын үсэг, байгууллагын тамга тэмдгээр баталгаажуулж, Хороонд хүргүүлнэ.
- 5.3 Аудитор нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараах дүгнэлтийн талаар Хороонд нэн даруй мэдэгдэнэ:
- 5.3.1 Даатгалын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу тухайн даатгалын байгууллагыг төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй;
 - 5.3.2 даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болзошгүй;
 - 5.3.3 даатгагч Даатгалын тухай хуулийн 22, 23, 24, 25, 26, 27 дугаар зүйлийг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзсэн;
 - 5.3.4 мөн тухайн байгууллага санхүүгийн онц хүндрэлтэй байдалд орж болзошгүй болсон;
 - 5.3.5 даатгуулагчдын эрх ашгийг зөрчсөн;
 - 5.3.6 шударга бус ажилласан;
 - 5.3.7 хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцсон.

ЗУРГАА. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж, шалгалт хийх ба холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.2 Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар эрх эзэмшигчдийн хооронд болон эрх эзэмшигч, үйлчлүүлэгчдийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэнэ.
- 6.3 Аудитор, үйлчлүүлэгч нар нь Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл тус Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.
- 6.4 Хяналтын зөвлөлийн гаргасан шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.

---ooOoo---

Зураг

“Аудиторт даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох тухай журам”-ын 1 дүгээр хавсралт

АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА,
АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОЛТ

А. Аудитын байгууллагад ямар албан тушаал эрхэлдэг талаар тэмдэглэнэ.

1. Аудитын байгууллагын дарга.....
2. Ахлах аудитор.....
3. Аудитор.....

Үүнээс: -даатгалын чиглэлийн
-бусад

Б. Аудитын байгууллага, аудиторуудын намтар, товч түүх:

1. Аудитын байгууллага:

- Оноосон нэр.....
- Байгуулагдсан он сар өдөр.....
- Байршил буюу хаяг.....
- Регистрийн дугаар №.....
- Улсын бүртгэлийн дугаар №.....

2. Аудиторууд:

- Овог нэр:.....
- Иргэний харьяалал:.....
- Иргэний үнэмлэхний №.....
- Регистрийн №.....
- Нийгмийн гарал:.....
- Гэрлэлтийн байдал:.....
- Эрхэлж байгаа ажил:.....
- Хаяг:.....
- Төрөл төрөгсөд болон ам бүл:

Товч танилцуулга: (Урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, даатгалын байгууллагатай харьцаж байсан түүх, даатгалын байгууллагын хувь нийлүүлэгч эсэх, Аудитын болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчиж хариуцлага хүлээж байсан эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн эсэх зэргийг тодорхой гаргацтай, үнэн зөв бичнэ):

.....
.....
.....

.....

.....

.....

.....

.....

.....

- Боловсролын талаар (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ):

Хаана ямар сургууль	Элссэн он сар	Төгссөн он сар	Эзэмшсэн мэргэжил	Диплом № Гэрчилгээ №

- Ажил, мэргэшлийн туршлагын талаар: (хөдөлмөрийн үйл ажиллагаа)

Ямар байгууллагад, ямар албан тушаалд ажилласан (албан газар, албан тушаалыг тэр үеийн нэрээр бичнэ)	Ажилд орсон	Ажлаас гарсан

- Гэрийн хаяг:.....
- Утасны дугаар:.....

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

/...../
(гарын үсэг)

/...../
(овог, нэр)